



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А133

Хажуу шинэ-Ус

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/96 тушаал, Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 8-ны өдрийн А/192 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой байгаль орчинд халгүй биологийн аргаар тэмцэх ажилд малчид, мал бүхий иргэд дэмжлэг үзүүлж бактержуулсан будаа цацах 1.2га талбайн бэлчээрийг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай чөлөөлсүгэй.

2.Бэлчээр чөлөөлөх хугацаанд хөдөлмөр хамгаалал, хүн амын эрүүл ахуйн шаардлагыг хангах талаарх мэдээллийг малчдад хүргэж малын хариуллага, маллагаатай байгаад хяналт тавихыг 3 дугаар багийн Засаг дарга (Н.Энхтайван)-д үүрэг болгосугай.

ДАРГА



БАРИУНАА